

## Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын

Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2015-05-25/

Ажлын хэсгийн 37 дугаар хуралдаан 2015 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 11.00 цагт “Пума империал” зочид буудлын хурлын танхимд зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Дэлгэрмаа, Уул уурхайн яамны СТБГ-ын Уул уурхайн хэлтсийн дарга Б.Нэргүй, мэргэжилтэн Т.Зууннаст, Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын мэргэжилтэн Г.Зулай, Авилгатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан Г.Сарангэрэл, Газрын тосны газрын санхүүгийн хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Н.Нямдорж, Татварын ерөнхий газрын татварын байцаагч Д.Энхтуяа, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацын гүйцэтгэх захирал Н.Энхболд, Хүний эрх хөгжил төвийн тэргүүн Г.Уранцож, МБОИЗ-ийн удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд, Ариун суварга хөдөлгөөний тэргүүн Г.Чагнаадорж, Хариуцлагатай уул уурхай ТББ-ын тэргүүн Л.Долгормаа, Ил тод сан ТББ-ийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, Нээлттэй нийгэм форумын менежер, ТАН эвслийн зохицуулагч Д.Эрдэнэчимэг, Бороо гоулд ХХК-ны татварын нягтлан бодогч П.Болормаа, Монполимет ХХК-ны захирал С.Энхтуяа, Саусгоби сэндс ХХК-ны Засгийн газар, олон нийтийн харилцах хэлтсийн дарга Б.Алтанбагана, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 17 гишүүн оролцож ирц 55 хувьтай байв.

Мөн хуралдаанд ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг, Мэдээллийн технологийн зөвлөх Г.Ганбат нар оролцов.

Хурлыг Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Б.Дэлгэрмаа удирдан явуулав.

Б.Дэлгэрмаа: Өнөөдрийн хурлаа шууд, цагтаа эхлүүлэх саналтай байна. Гишүүд санал нэгтэй гарaa өргөв.

Үүний дараа хурал даргалагч хэлэлцэх асуудал болон дотоод журмыг танилцуулж, өөр санал гаргаагүй тул хурлаа эхлүүлэв.

### 1. ХЭЛЭЛЦСЭН нь: Монголын ОҮИТБС-ын цахим тайлангийн журам

Г.Ганбат: ОҮИТБС-ын жил бүрийн тайлан авах үйл явцад мэдээллийн технологийг ашиглах, цаасгүй технологи нэвтрүүлэх, тайлан гаргах, хүлээн авах, тулган баталгаажуулах үйл ажиллагааг хялбар болгох, ОҮИТБС-ын тайлангийн мэдээллийн нэгдсэн санг бий болгох, мэдээллийн хүртээмжийг сайжруулах зорилгоор “Цахим тайлан” системийг Европын сэргээн босголт банкны санхүүжилт, Адам Смит байгууллагын тусламжтайгаар 2014 оны 9 сард боловсруулсан билээ.

ОҮИТБС-ын 2014 оны тайланг энэхүү цахим тайлангийн системээр хүлээн аваад байна. Тайлан гаргасан байдлыг танилцуулахад, цахим тайлангийн системд нийт 1050 компани бүртгүүлснээс 987 компани тайлангаа илгээсэн, 753 компани тайлангаа гаргаагүй байна. Төрийн байгууллагаас 32 байгууллага тайлангаа гаргаж, 3 байгууллага хадгалсан төлөвтэй, 8 байгууллага огт гаргаагүй байна.

ОҮИТБС-ын цахим тайлагналын системийн журмыг ОҮИТБС-ын тайланг цахим хэлбэрээр илгээх, хүлээн авах, мэдээллийг ил тод болгох, цахим системийг хөтлөхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор боловсруулсан. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, цахим тайлагналын систем, компанийн хэрэглэгчид тайлагнах, төрийн байгууллага тайлагнах, тулган баталгаажуулалт хийх, мэдээлэл солилцох, бусад гэсэн долоон зүйлээс бүрдэнэ.(Танилцуулга, журмыг хавсаргав)

Хурал даргалагч танилцуулсан мэдээллийн технологийн зөвлөх Ганбатад талархал илэрхийлж, асуулт, санал байгаа эсэхийг гишүүдээс лавлахад, санал байхгүй байсан тул гишүүд санал нэгтэй журмää батлав.

Б.Дэлгэрмаа, гишүүдэд баярлалаа. Манай ажлын албанаас ОҮИТБС-ын тайланг цахим тайлангийн системтэй болсонд баяр хүргэе, сайн ажилласан байна.

Хөтөлбөрийн дагуу дараагийн асуудалдаа оръё. Хүний эрх хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоож танилцуулна.

2. ХЭЛЭЛЦСЭН нь: ОҮИТБС-ын Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Г.Уранцоож: ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд нэгтгэл тайлангаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтэд мониторинг хийсэн. Өмнө нь ажлын хэсгийн хуралд танилцуулсан. Санаачилгын хэрэгжилтийг хангах Үндэсний зөвлөл, ажлын хэсэг, ажлын албаны үйл ажиллагaa зарим талаар тодорхой бус байна. Иймд холбогдох дүрэм журамд өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа тул санал боловсруулж байна. (Танилцуулгыг хавсаргав)

Б.Дэлгэрмаа: Үндэсний зөвлөлийн гишүүн Уранцоожид баярлалаа. Асуулт байна уу? Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай маш хэрэгтэй, ажил хэрэгч саналууд байна. Зөвшөөрч байгаа гишүүд гаралт өргөнө үү. Сайн ажилласан байна. Асуулт байхгүй бол саналыг багцаар нь батлах уу, зүйл бүрээр нь батлах уу? Саналтай хүн байхгүй байна, баталлаа, гишүүдэд баярлалаа. Одоо Т.Зууннастын танилцуулгыг сонсъё.

Т.Зууннаст: Манай ажлын хэсэг 2015 оны 1 сард байгуулагдсан. Ажлын хэсэгт Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын мэргэжилтэн Г.Зулай, Ашигт малтмалын газрын мэргэжилтэн Г.Оюунтуяа, Хүний эрх хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоож, Бороо гоулд ХХК-ны татварын нягтлан бодогч П.Болормаа, Оюутолгой ХХК-ны засгийн газар, олон нийтийн харилцааны мэргэжилтэн Х.Лхамаа нар ажилласан. (Танилцуулгыг хавсаргав)

Б.Дэлгэрмаа: Баярлалаа, асуулт асуух гишүүн байна уу.

Г.Уранцоож: Үндэсний зөвлөлийн хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа хуралдуулах, ажлын хэсгийн хуралдааныг улиралд 1-ээс доошгүй удаа хуралдуулах санал оруулсан. Дээрх саналуудыг бид дэмжиж байна. Бид жилдээ нэг удаа хуралдахаар зөвхөн тайлангийн тухай ярилцсаар таардаг. Үүнийг харгалзаж үзээрэй.

Т.Зууннаст: Хуулийн төслийн батлуулахаар Эдийн засгийн байнгын хороо ажиллаж байгаа. Хэрвээ хууль батлагдвал Үндэсний зөвлөлийн хурлыг журмын дагуу хийх боломжтой.

Б.Дэлгэрмаа: Хэрвээ хууль батлагдахгүй бол яах вэ? Чуулганаар хэлэлцэж байхад зарим гишүүд нэлээд эсэргүүцэж байсан.

Г.Уранцоож: Бид заавал хууль хүлээхгүйгээр ҮЗ болон ажлын хэсгийн хуралдааны тоонд өөрчлөлт оруулах боломж байхгүй юу?

Б.Дэлгэрмаа: Үндэсний зөвлөлийн хуралдааныг Ерөнхий сайд ахлах гэдэг утгаараа жилдээ 1-ээс доошгүй удаа хуралдуулна гэж оруулсан байгаа. Хэрэв ОҮИТБС-ын тайлангийн хурлаас бусад тохиолдолд нарийн бичгийн даргаар удирдуулаад шаардлагатай асуудлаа хэлэлцээд хуралдана гэвэл би цаг зав гаргаад оролцох бүрэн боломжтой юм. Бид ажлын хэсгийг улам идэвхтэй, нягт ажиллуулах үүднээс таван ажлын хэсэг байгуулаад ажиллаж байгаа, эрчимтэй, сайн ажиллаж байгаа гэж бодож байна. Дүрмээрээ зохицуулаад явах боломжтой байх.

За, гуравдугаар асуудалдаа оръё. ОҮИТБС-ын тэргүүн хатагтай манай улсад айлчлах гэж байгаа. энэ талаар ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулна.

3. ХЭЛЭЛЦСЭН нь: ОҮИТБС-ын тэргүүн хатагтай К.Шортын айлчлалын бэлтгэлийн тухай

Ш.Цолмон: Хатагтай К.Шортын айлчлал 2015 оны 6 дугаар сарын 3-наас 6-ны хооронд болно. 3-ны өдөр баталгаажуулалтын семинар болно. Семинараар ярилцах асуулт болон хөтөлбөрийг урьдчилсан байдлаар тараасан. 4-ны өдөр 14-16 цагийн хооронд Үндэсний зөвлөлийн хуралдаан зохион байгуулна. (Танилцуулга, хөтөлбөрийг хавсаргав)

Б.Дэлгэрмаа: Хөтөлбөртэй холбоотой санал, асуулт байна уу?

Д.Эрдэнэчимэг: Ерөнхийлөгч, ерөнхий сайдтай уулзах цаг нь тодорхой болно гэж үзэж байна уу?

Ш.Цолмон: Тийм, цаг нь тодорхой болохоор ойрхон газар уулзалтаа зохицуулж болох болов уу гэсэн хүсэлттэй байна.

Д.Нэргүй: Бодлогын зөвлөлд орж байгаа мэргэжлийн холбоод, ИНБ-аас тусдаа гэж ойлгож болох уу?

Б.Дэлгэрмаа: Тус тусдаа уулзана, нэг нь яаман дээр нөгөө ИНБ-ийнхан Засгийн ордон хавьцаа уулзвал зүгээр байх.

Б.Батболд: ИНБ-ийн уулзалтад Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн гишүүд уулзах уу?

Ш.Цолмон: Энд аль болох нээлттэй байх ёстой гэсэн, заавал гишүүд гэж хязгаарлахгүй юм. Гэхдээ хэт олон болов зохион байгуулахад хүндрэлтэй болно.

Б.Дэлгэрмаа: Манайд Үндэсний зөвлөл, ажлын хэсэгт хэчинээн ИНБ байна вэ? ТАН эвслийн төлөөлөл 9 гишүүн, МБОИЗ-ын төлөөлөл 2 гишүүн бүгд уулзвал болох юм. Харин хатагтай Шорттой уулзах чин хүсэлтэй хүн байвал уулзаж болох ч, хэт задгайрах бас дэний.

Н.Долгормаа: Үндэсний зөвлөлд таван ажлын хэсгийн танилцуулга хийхэд ажлын хэсгүүд маань сайн бэлдмээр байна.

Б.Дэлгэрмаа: Үндэсний зөвлөлд танилцуулга хийх ажлын хэсгийн гишүүдээ сайн томилж, бэлтгүүлэх шаардлагатай байна. Ойролцоогоор нэг хүн 5 минут орчим

байхад болно. Ерөнхий сайдын уулзалтын цагийг би зохицуулж болно. Харин ерөнхийлөгчийн цаг тодорхой болоогүй учраас товлож чадахгүй хүлээгээд байна.

За зохицуулагч Цолмонд баярлалаа. Ажлын дэд хэсгүүдийн танилцуулгаа сонсъё.

**ХЭЛЭЛЦСЭН нь:** ОҮИТБС-ын 2013 оны тайлангийн мөрөөр хэрэгжүүлэх ажлыг боловсруулах ажлын 5 дэд хэсгийн сонсгал

**Бо.Дэлгэрмаа (ажлын алба):** Нэгдүгээр ажлын хэсгийн ажлын явцыг танилцуулъя. Бид уул уурхайн салбарын орлогын бүртгэлийг нягтлах, давхар бизнесийн орлоготой холбоотой төлөгдөж буй татварыг тусад нь бүртгэн тайлагнах боломжийг судлах зорилгоор уул уурхайн салбарын орлогыг судлан нийтэд мэдээлж буй ОҮИТБС-ын тайлан бэлтгэх аргачлалыг судлах, өөр салбарт давхар бизнес эрхэлдэг компаниудын орлого уул уурхайн салбарын орлогод хэдэн хувь эзэлж байгааг судалж, тус орлоготой холбоотой төлөгдөж буй татварын хэмжээ нь материаллаг эсэхийг тогтоох, давхар бизнесийн орлого, холбогдох татварыг тусад нь бүртгэх боломжтой эсэхийг тодорхойлохоор ажиллаж байна.

Одоогийн байдлаар ажлын хэсэг нэг удаа хуралдаад байна. Хуралдаанаар уул уурхайн салбарын орлогыг ямар хүрээнд авч үзэх, түүнийг тодорхойлж байгаа аргачлал, цар хүрээг дэлгэрүүлж судлах, давхар бизнесийн орлогыг тодорхойлохын тулд 2013 онд тайлан гаргасан 1660 компаниас 93 компанийг сонгон авч тэдгээрийн санхүүгийн тайлан, ОҮИТБС-ын тайлан зэргийг харьцуулан судлах, судалгааны үр дүнд үндэслэн ОҮИТБС-ын тайланд уул уурхайн орлогыг илүү бодитойгоор буюу өөр салбарт давхар бизнес эрхэлж буй компанийн тайланд уул уурхайн бус татваруудыг хасаж тусгах боломжийн талаар зөвлөмж гаргах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна. (Танилцуулгыг хавсаргав)

**Б.Дэлгэрмаа:** Гэтэл эдний ажлыг хэдэн хувьтай гэж үзэх вэ? Ажлын хэсгийн явц ядаж 50 хувь байсан бол Үндэсний зөвлөлийн хуралд танилцуулах боломжтой юм.

**Бо.Дэлгэрмаа:** Бид давхар орлогыг тодорхойлох талаар судалж байна. Энэ нь компани талдаа боломжтой боловч төрийн байгууллагуудын хувьд төвөгтэй байгаа юм.

**Б.Дэлгэрмаа:** Энэ ажлын хэсгийг Үндэсний зөвлөлийн хуралдаанд оруулах талаар гишүүд шийдэх байх.

**Д.Нэргүй:** Үндэсний зөвлөлийн хуралдаанд ажлын явц гайгүй байгаа хэсгүүдийн танилцуулгыг оруулаад иймэрхүү дутуу байгаа ажлын хэсгүүдийг тусад нь оруулвал зүгээр болов уу.

**Б.Дэлгэрмаа:** Дараагийн дөрөвдүгээр ажлын хэсгийн танилцуулгыг сонсъё. Ажлын хэсгийн ажилтан Дэлгэрмаа танилцуулна.

**Бо.Дэлгэрмаа:** Манай ажлын хэсэг нь эрдэс баялгийн салбар дахь гэрээг ил тод болгох, ач холбогдлыг судлан тогтоох, талуудыг нэгдсэн ойлголтод хүргэх зорилгоор эрдэс баялгийн салбар дахь гэрээний ил тод байдлыг хангахад тулгарч буй бэрхшээл, талуудын байр суурь, ил тод болгосноор бий болох ач холбогдол, үр нөлөөг судлах, зөвлөмж боловсруулахаар ажиллаж байна. Бид энэ хугацаанд 2 удаа хуралдаж, ажлын явц 70-75 хувьтай явж байна. (Танилцуулгыг хавсаргав)

**Б.Дэлгэрмаа:** За баярлалаа, дөрөвдүгээр ажлын хэсэг маань амжилттай явж байгаа юм байна. Иймээс Үндэсний зөвлөлд оруулах саналтай байна. Танилцуулгаа сайн бэлдээд багийн ахлагч нар нь илтгэлээ тавих хэрэгтэй байх.

**Б.Нэргүй:** Манай ажлын хэсгийн ажил хэрэгч ажил нь бодитой цахим сан (сайт) боловсруулах юм. Бид Нээлттэй нийгэм форумд танилцуулж, хамтарч ажиллахаар ярьсан байгаа. Ил тод болсон гэрээний нэгдсэн цахим санг боловсруулах зөвлөх компанийг сонгон шалгаруулахаар бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.

**Б.Дэлгэрмаа:** Та нар ажил хэрэгч юм хийж байгаа нь харагдаж байна. Нарийн бичгийн дарга нар бэлтгэлээ хангаад, ахлагч нар танилцуулгаа хийх хэрэгтэй.

Цааш нь ажлын хэсгийн танилцуулгаа үргэлжлүүлэн сонсоод, Үндэсний зөвлөлд тавих бэлтгэлээ сайн хангаарай. Гишүүд дараагийн зохион байгуулах ажилд идэвхтэй оролцоорой. Иргэний нийгмийн байгууллагууд ирцээ сайн бүрдүүлээд, уулзалтдаа идэвхтэй оролцно биз. Бид хоорондоо эвтэй, найрсаг байх ёстой, монголчууд гэдгээрээ бахархах хэрэгтэй. Гадна дотнын хүмүүстэй уулзахдаа буруу зөрүү юм ярихгүй байх, бие биенээ хайлаж, хүндэтгэж ажиллах хэрэгтэй байна.

За та бүхэнд баярлалаа, зайлшгүй ажлын шаардлагаар би чөлөө авах хэрэгтэй байгаа тул хүлцэл өчье. Та бүхэнд амжилт хүсье.

**Ш.Цолмон:** Хоёрдугаар ажлын хэсэг нь байгаль орчныг нөхөн сэргээх барьцаа төлбөрийн түвшинг зохистой болгох зорилгоор байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль хамгаалах төлөвлөгөө, барьцаа төлбөр, буцаан олголт, байгаль орчны нөхөн сэргээлтийн мониторинг зэрэг байгаль хамгаалахад чиглэсэн бүх үе шатуудад судалгаа хийж, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, талууд харилцан зөвшилцэж, нэг мөр ойлголтод хүрэх, дүгнэлт зөвлөмж боловсруулахаар ажиллаж байна. Ажлын хэсэг энэ хугацаанд 3 удаа хуралдаж, гишүүн Болормаа, Баярмаа, Энхтуяа нар БОНХАЖЯ дээр ажиллаж байгаль орчны барьцаатай холбоотой бүх материалуудтай танилцаж, ямар хэмжээний судалгаа хийх дүгнэлт хийж болохыг тодорхойлон, 5 дугаар сарын 29-ны өдөр ажлын хэсэгтээ эргэн танилцуулах, түүний үндсэн дээр Үндэсний зөвлөлийн хуралд танилцуулга бэлдэхээр ажиллаж байна. Мөн 8 шалгуур үзүүлэлтийн дагуу ажлын хэсгийн гишүүд компаниудаа хуваарилж аваад судалгаа хийхээр болсон. Байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн эрхзүйн зохицуулалтын судалгааг Тuyaцэцэг танилцуулахаар төлөвлөж байгаа, учир нь Тuyaцэцэг маань энэ талаар нэлээн их судалгааны ажил хийсэн, туршлагатай тул үүнийгээ санаачилгын хүрээнд бусдад ил тод болгох, мэдээлэл өгөхийг зорьсон юм. Бид одоо нэг удаа цуглаад, судалгаагаа эцэслээд Үндэсний зөвлөлийн хуралд танилцуулах бүрэн боломжтой гэж үзэж байна. (Танилцуулгыг хавсаргав)

За, дараагийн тавдугаар ажлын хэсгийн явцын талаар товч танилцуулъя. Энэ ажлын хэсэг маань уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдэд хууль жигд ялгаваргүй үйлчлэх болон АМНАТ, жишиг үнийн асуудлыг ойлгомжтой болгох зорилгоор уул уурхайн салбарын тэргүүлэгч аж ахуйн нэгжүүдийн одоогийн татварын хувь хэмжээ, гэрээний нөхцөл, үндэслэл, талуудын байр суурь, хуулийн зүйл, заалтуудыг судлах, зөвлөмж боловсруулахаар ажиллаж байна.

Ажлын хэсэг 12 гишүүнтэй, нэг удаа Сангийн яаманд хуралдаж ажлын хэсгээс ямар хувь нэмэр оруулж болох талаар хэлэлцсэн. Цаашдаа 5 дугаар сарын 26-ны

өдөр уулзаж, Үндэсний зөвлөлийн хуралдаанаас өмнө санал боловсруулж, танилцуулга хийхээр төлөвлөж байна. (Танилцуулгыг хавсаргав)

Г.Уранцоож: Би энэ ажлын хэсэгт орсон боловч татварын талаарх ойлголт муу тул сайн оролцож чадахгүй байгаа.

Ш.Цолмон: Тавдугаар ажлын хэсгийг Үндэсний зөвлөлд танилцуулах талаар гишүүд юу гэж бодож байна.

Л.Долгомаа: Материалаасаа шалтгаалах байх. Дараагийн уулзаж ярилцаад санаанд таарсан боллоо гэж үзвэл Үндэсний Зөвлөлийн хуралдаанд танилцуулъя.

Ш.Цолмон. Бид маргааш цуглахаар ярилцсан байгаа. Алгаа захирлын оронд Б.Энхболд тавдугаар ажлын хэсэгт орж байгаа гэж ойлгосон шүү.

Б.Энхболд: АМНОТ-ын судалгаа хийгдсэн материал хангалттай байна.

Ш.Цолмон: Өөр өөр өнцгөөс харсан байгаа. Нэгдсэн нэг юм байхгүй. Хоёр тавдугаар ажлын хэсгүүд дараагийн уулзалтаараа шийдвэрлэнэ гэсэн байдлаар тохирох уу.

Д.Эрдэнэчимэг: Энэ найман шалгуур үзүүлэлт гэдэг чинь хариуцлагатай уул уурхайн шалгуур уу?

Б.Батболд: Бид өөрсдөө судалгаа хийгээд ийм үзүүлэлтуүдийг оруулъя гэсэн.

Л.Долгомаа: Тэр бол биш шүү. Байгаль хамгаалах төлөвлөгөө байна уу, үгүй юу энэ тэр зүйлийг шалгах асуудал биш юм. Тэртэй тэргүй компаниудад байгаа болоод үйл ажиллагаа явуулж байгаа. Бид байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг 50 хувиар бодитой хийж байна уу гэдэг дээр ажиллах ёстой. Дараагийн асуудал бол тэр 50 хувийн мөнгийг ямар дансанд байна, авах болохоор нэхээд авдаг, буцаагаад өгөх болохоор дарамттай байдаг. Үүнийг бид бодит байдал дээр ямар байгааг судлах хэрэгтэй. Энэ асуудал нь байнгын нууц, хэзээ ч ил гардаггүй учраас үүнийг ил болгоё гэсэн болохоос төлөвлөгөө энэ тэр байна уу гэдгийг судлах ажил биш юм.

Б.Батболд: Тэр талаар биш, байршуулсан мөнгөө буцааж авч байгаа компаниуд үнэхээр нөхөн сэргээлтээ бодитоор хийж байна уу гэдэг юм.

Л.Долгомаа: Хийсэн болоод л мөнгөө буцааж авч байгаа шүү.

Г.Чагнаадорж: Тэр чинь хийсэн болоод л авч байгаа, зүгээр авьяя гэсний зоргоор өгөхгүй.

С.Энхтуяа: Барьцаа мөнгөн дээр хүү тооцогддоггүй. Уг нь их олон тэрбум төгрөг дээр хүү тооцох нь зөв юм.

Д.Эрдэнэчимэг: АТГ эсвэл Байгаль орчны яам нөхөн сэргээлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгээд, дутаж байгаа хөрөнгийг үл маргах журмаар гаргуулж авна гэсэн заалт байдаг. Тэр заалтын хэрэгжилтийг харж үзээч. Байгаль орчны яам нэлээд хэдэн компанийн байгаль орчны хохирлыг тооцуулаад өчнөөн төгрөг зараад хийсэн. Үүнд улсын төсвөөс хэдийг зарсан, компаниудын байгаль орчны хохирлыг

тооцох үнэлгээ хийлгэдэг байгаа. Үнэлгээний зардлаа эргээд нөхөн сэргээх зардлын хамт компаниудаас гаргуулж авах ажил хийгдэхгүй байна үүнийг танай ажлын хэсэг судлах боломжтой юу?

Л.Долгормаа: Хохирлын мөнгийг авсан уу гэсэн үг үү?

Д.Эрдэнэчимэг: Нөхөн сэргээлтийн 50 хувийг байршуулдаг, энэ бол нийт зардал биш үүн дээр нөхөн сэргээлтээ хийхгүй орхисон тохиолдолд Байгаль орчны яам мэргэжлийн компанийтай гэрээ байгуулаад нөхөн сэргээлтийг хийлгээд барьцаа тавин хувиас илүү гарсан үлдсэн 50 хувийг үл маргах журмаар гаргуулна гэсэн заалт Ашигт малтмалын тухай хуулийн 39-т байдаг.

Л. Долгормаа: Энэ талаар сонсоогүй юм байна.

Д.Эрдэнэчимэг: 2010 онд нөхөн сэргээлтийн тооллого явуулаад улсад төчнөөн хэмжээний хохирол учирсан байна гээд яриад байсан. Тэр хохирлыг компаниудаас гаргуулж авах ёстой, энэ ажил хийгдэхгүй байна.

Ш.Цолモン: За зүйтэй, манай ажлын хэсэг дээр нэмэлт судалгаа орж ирж байна. Тавдугаар ажлын хэсэгтэй холбогдуулаад өөр санал, асуулт байна уу?

Асуулт байхгүй бол дараагийн гуравдугаар ажлын хэсгийн мэдээллийг сонсъё.

Г.Ганбат: Энэхүү ажлын хэсгийн зорилго нь тайлاغнах, нэгтгэх үйл явцыг хялбаршуулах, Засгийн газрын болон компанийн тайланг аудитаар баталгаажуулах боломжийг судлах явдал юм. Бид ОУИТБС-ын тайлангийн маягтыг дахин нягтлах, ОУИТБС-ын тайлангийн маягт бөглөх зааврыг боловсронгуй болгох, Засгийн газрын мэдээлэл цуглуулах процессыг нягтлах, мэдээллийн найдвартай байдлыг хангах, аудитын нэгтгэлээр гаргаж өгөх нэмэлт мэдээллийн жагсаалт гаргах, түүнд тохирсон маягт боловсруулах, аудитын ажлын даалгаварт оруулах, компаниудын болон Засгийн газрын ОУИТБС-ын тайланг аудитаар баталгаажуулах боломжийг судлах, зөвлөмж гаргахаар ажиллаж байна. Ажлын хэсэг энэ хугацаанд гурван удаа уулзаж, санал солилцсон бөгөөд хийх ажлын жагсаалт гаргаж, одоогийн байдлаар хийх ажлынхаа 70 орчим хувийг хийгээд байна. Мөн "Google group" үүсгэн хоорондоо холбогдон гишүүдээс санал авах, мэдээлэл солилцохдоо ашиглаж байна. Компаниудын маягт өөрчлөх ажил ерөнхийдөө дууссан байгаа. Одоо та бүхэнд танилцуулаад санал авна. Заавал хийх ажлын даалгаврын хүрээнд хөрөнгө оруулгын мэдээлэл цуглуулах талаар судалгаа авах ажил байгаа. Компаниудын болон төрийн байгууллагуудын тайланг аудитаар баталгаажуулах ажлын талаар компаниудын тайланг аудитаар баталгаажуулах шаардлагагүй гэж үзсэн байгаа харин төрийн байгууллагуудын тайланг Үндэсний аудитын газраас баталгаажуулсан байх шаардлагатай гэж үзсэн. Цаашдаа санал дүгнэлтээ нэгтгэж боловсруулна, маягтад орох өөрчлөлтөө оруулж санал авах зарим төрийн байгууллагуудаас санал авна. Үндэсний аудитын газар, АМГ-аас санал авахаар тохирсон байгаа. Тайлангийн маягтад дараах өөрчлөлтүүдийг оруулахаар боловсруулж байна, тайлангийн хугацааны хувьд төрийн байгууллагууд болон орон нутгийн байгууллагуудыг 5 сарын 31-ны дотор, компаниуд 5 дугаар сарын 31-ны дотор тайлангаа гаргахаар болж байна. Төрийн байгууллагуудын бусад гэсэн үзүүлэлтийг хасах саналтай байгаа. Усны бохирдлын төлбөрийг шинээр нэмэх, ХХОАТ-ыг сайн дурын мэдээлэлтэй нэгтгэх санал байна. Мөн 1,2 дугаар маягтыг нэгтгэх зэрэг нийт 17 өөрчлөлтийг оруулахаар төлөвлөж байна. Мөн ажлын даалгаврын 1,2,3 дугаар ажлын хүрээнд ОУИТБС-ын тайлан болон цахим тайлангийн талаарх судалгааг

компанийн 691 ажилтан, төрийн 48 ажилтанд тус тус илгээж хариуг хүлээн авлаа. Мөн ОҮИТБС-ын тайланд анхны зөрүү үүсгэж буй нийтлэг шалтгаан, 2014 оны тайланг цахим системээр хүлээн авахад тулгарч буй хүндрэлийг багасгах зорилгоор зөвлөмжийг боловсруулсан.

Бид нийт төлөвлөсөн ажлын 60-70 хувийг хийсэн одоо зарим нэг тодруулгыг аваад санал, дүгнэлтээ нэгтгэвчихвэл Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулах бүрэн боломжтой гэж үзэж байна. Тайлангийн маягтыг Үндэсний зөвлөлийн хурлаар баталчихвал ашиглах боломжтой болох байх. (Танилцуулгыг хавсаргав)

Ш.Цолмон: Маягтын хувьд Сангийн яам, Статистикийн хороогоор батлуулах шаардлагатай байдаг.

Л.Долгормаа: Статистикийн хороогоор батлуулахад бараг сарын хугацаа орох байх.

Ш.Цолмон: Уг нь тийм, гэхдээ Статистикийн хорооны дарга нь манай Үндэсний зөвлөлийн гишүүн учраас харьцангуй нааштай, хурдан ажиллах боломжтой байдаг. Ингээд гуравдугаар ажлын хэсгийн хувьд Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулах бүрэн боломжтой гэж үзээд баталья. Өөр санал байна уу, хурлын материалд шийдвэрийн төсөл тараасан байгаа үүнийг 3,4,5 дугаар ажлын хэсгийн саналыг нэгтгэж Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч нарт даалгав гэдгийг хэвээр үлдээх үү?

Л.Долгормаа: Шийдвэрийн төслөө энэ хэвээр нь байлгах саналтай байна.

Д.Энхтуяа: Тавдугаар ажлын хэсэг дахин боловсруулаад ажлын хэсгийн хуралдаанд дахин танилцуулахаар болсон биз дээ.

Ш.Цолмон: Энэ тавдугаар ажлын хэсгийн хувьд Эрдэнэт үйлдвэр болон Оюу толгой компанийн мэргэжилтнүүд бараг Засгийн газрын тогтоолын хэмжээнд боловсруулсан гэж үзэж байгаа учир цаг алдалгүй Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулах боломжтой гэж үзэж байна. Үндэсний зөвлөлийн гишүүн Галбаатар гуай нэлээд санаачилга гаргаад, идэвхтэй оролцож байгаа ба тэрээр өөрөө танилцуулга хийх юм.

Г.Уранцоож: Энэ ажлын хэсгийн гишүүдийн хувьд ИНБ-аас 2-хон хүн байна, үүний нэг нь би негөө нь Төр-Од бид 2 байна. Гэхдээ миний хувьд татварын асуудлаар жаахан муу. Уг нь татварын асуудал хамгийн чухал бөгөөд энэ талаар ямар санал гарч байгааг бусад ИНБ-үүд, ТАН эвсэл үзэж, харах хэрэгтэй байх гэсэн санал байна. Тэгэхгүй бол ямар санал дүгнэлт ажлын хэсгээс гаргаад Үндэсний зөвлөлд оруулах гэж байгааг мэдэхгүй л байна. Иймээс нэг талын оролцоо нь ямар ч ойлголтгүй хүмүүс байгаад ажлын хэсгийн хуралдаанд бараг оролцоогүй санал дүгнэлтийг Үндэсний зөвлөлд танилцуулах нь ямар бол? Иймээс ИНБ-уудыг Үндэсний зөвлөлийн хуралдааны өмнө танилцах нь зүйтэй гэж бодож байна.

Ш.Цолмон: Тэгвэл маргааш тавдугаар ажлын хэсгийн уулзалт болно, түүн дээр ирээд сонсох боломжтой юм.

Г.Уранцоож: Уучлаарай, маргааш би бас боломжгүй.

Б.Батболд: Маргааш бид нар очоод сонсчихвол яасан юм, бэлэн гээд яваад цаг болохоор юу ч болох юм билээ.

Ш.Цолмон: Тэгвэл маргааш ИНБ-ийнхан нэмэлт байдлаар очоод танилцана уу. Харин 3,4 дүгээр ажлын хэсгийг Үндэсний зөвлөлд танилцуулахаар шийдвэрлэж, 1,2 дугаар ажлын хэсгийн хувьд дахин ажиллах шаардлагатай байх.

Д.Эрдэнэчимэг: ТАН эвслээс нэг хүн нэмж оруулах санал байна.

Ш.Цолмон: Тэгэхээр маргааш тавдугаар ажлын хэсгийн хуралд ирэх хүний өгнө үү. АМНАТ-ын асуудал нэлээд судлагдчихсан, Засгийн газрын тогтоолын түвшинд боловсруулагдсан тул Үндэсний зөвлөлд танилцуулах боломжтой гэж үзэж байгаа.

Б.Нэргүй: Энд чинь хүндрэлтэй асуудлууд байгаа, тухайлбал гэрээний үнэ гэх мэт. Жишиг үнэ тавьчих бас хүндрэлтэй байгаа гэхдээ хүмүүст ойлголт өгч байвал зөв, Гэхдээ ганцхан Засгийн газар талаасаа юм уу яам талаасаа танилцуулаад байхаар нэг маягийн болоод байна. Уул уурхайн яам бол уурхайчид компаниудаа дэмжээд ашигтай ажиллуулах санаатай байдаг, харин Сангийн яам бол татварын бодлогоор компаниудаас мөнгө авах сонирхолтой байдаг. Тэгэхээр Д.Эрдэнэчимэгийн хэлснээр хөндлөнгийн судалгаа хийсэн байгууллагаар танилцуулга хийлгэсэн нь зүгээр юм. Заавал яам гэх шаардлагагүй байна.

Б.Батболд: АМНАТ-ын асуудлын хувьд бэлэн байгаа хүмүүс нь яам юм уу компаниудын төлөөлөл байгаа. Бид юу бэлэн байгааг мэдэхгүй байгаа учраас эхлээд сонсчихвол зүгээр байна.

Б.Нэргүй: ИНБ-аас судалгаа хийгдсэн үү?

Ш.Цолмон: ТАН эвслийн санал нь шинээр хүн оруулъя гэсэн юм.

Б.Нэргүй: Тэгвэл Уул уурхайн ассоциацаас танилцуулж болно.

Ш.Цолмон: Уг нь Алгаа гуай байгаа л даа.

Энхболд: Тэгэхээр хөндлөнгөөс биш болно.

Ш.Цолмон: Маргаашийн хуралдаанд хэн ирэх вэ? Мөн Эрдэнэтээс ирсэн материал байгаа түүнийг та нарт явуулна. 3,4 дүгээр хэсгүүд танилцуулгаа бэлдэх хэрэгтэй байх. Хоёрдугаар хэсгийг эргэж ярилцахаар боллоо, өнөөдрийн хурал амжилттай өндөрлөж байна. Та бүхэнд баярлалаа.

Хуралдаан 12,45 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:  
Ажлын хэсгийн ахлагч Б. Дэлгэрмаа

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн ажилтан А.Огонтунгалаг